



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 20

Мандалговь

┌ Сумын 2019 оны төсөв батлах тухай ┐

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 64.1.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь :

1. Сумын 2019 оны төсөвт төвлөрүүлэх орлогын нэр төрөл, хэмжээг дор дурдсанаар баталсугай.

| д/д | Байгууллага, орлогын нэр төрөл | Орлогын дүн /мянган төгрөг/ |
|-------------|---|-----------------------------------|
| 1.1. | Сумын төсвийн татварын орлого | 518 121,5 |
| 1.1.1. | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар | 111 600,0 |
| 1.1.2. | Бууны албан татвар | 3 303,0 |
| 1.1.3. | Улсын тэмдэгтийн хураамж | 30 113,3 |
| 1.1.4. | Хадгаламжийн хүүгийн орлого | 260 105,2 |
| 1.1.5. | Хөрөнгө борлуулсны орлогын 2 % | 45 000,0 |
| 1.1.6. | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 57 000,0 |
| 1.1.7. | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны | 11 000,0 |
| 1.2. | Сумын төсвийн татварын бус орлого | 44 145,0 |
| 1.2.1. | Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг | |
| 1.2.2. | Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого | 40 617,5 |
| 1.2.3. | Хууль тогтоомжийн дагуу сумын төсөвт орох бусад орлого | 3 527,5 |
| | Нийт дүн | 562 266,5 |

2. Сумын 2019 оны төсвийн жилд төвлөрүүлэх зарлагын нийт хэмжээг 11,007,255.9 мянган төгрөгөөр баталж төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

| д/д | Төсвийн захирагч | Зардлын дүн /мянган төгрөг/ |
|--------|---|--------------------------------|
| 3.1. | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга | 81 942,0 |
| 3.1.1 | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга урсгал зардал | 81 942,0 |
| 3.2. | Засаг дарга | 560 140,3 |
| 3.2.1. | Засаг даргын Тамгын газар урсгал зардал Орон нутгийн нөөц сан | 522 013,5 38 126,8 |
| 3.2.2. | Эрдмийн далай цогцолбор сургууль Тогтмол зардал | 367 148,5 |
| | Говийн ирээдүй цогцолбор сургууль Тогтмол зардал | 314 915,7 |
| | Хүмүүнлэг сургууль Тогтмол зардал | 123 000,3 |
| | МГСургалттай сургууль Тогтмол зардал | 134 064,9 |
| | Мандал сургууль Тогтмол зардал | 312 917,0 |
| | 1 цэцэрлэг Тогтмол зардал | 31 525,9 |
| | 2 цэцэрлэг Тогтмол зардал | 36 094,7 |
| | 3 цэцэрлэг Тогтмол зардал | 49 705,4 |
| | 4 цэцэрлэг Тогтмол зардал | 48 092,1 |
| | 5 цэцэрлэг Тогтмол зардал | 49 025,0 |
| | 6 цэцэрлэг Тогтмол зардал | 48 790,6 |
| | 7 цэцэрлэг Тогтмол зардал | 31 886,3 |
| | 8 цэцэрлэг Тогтмол зардал | 24 444,9 |
| | Эрүүл мэндийн төв Тогтмол зардал | 19 328,0 |
| | Орон нутгийн хөгжлийн сан | 196 997,5 |
| | Тусгай зориулалтын төсөл сан | 645 991,1 |
| | Нийт дүн | 3 076 010,2 |

3. Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 1 614 842,7 мянган төгрөгөөр баталсугай;

4. Сумын төсвөөс 2019 оны төсвийн жилд төсвийн шууд захирагчдад олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

| Д/д | Сум (дүүрэг)-ын нэр | Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ | Ерөнхий боловсролын үйлчилгээ | Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ |
|-----------------|-----------------------------------|--|-------------------------------|---|
| 1 | 1 цэцэрлэг | 277 341,9 | | |
| 2 | 2 цэцэрлэг | 280 969,7 | | |
| 3 | 3 цэцэрлэг | 412 379,7 | | |
| 4 | 4 цэцэрлэг | 331 709,1 | | |
| 5 | 5 цэцэрлэг | 349 883,4 | | |
| 6 | 6 цэцэрлэг | 331 302,4 | | |
| 7 | 7 цэцэрлэг | 269 837,1 | | |
| 8 | 8 цэцэрлэг | 226 798,9 | | |
| 9 | Эрдмийн далай цогцолбор сургууль | | 1 590 102,5 | |
| 10 | Говийн ирээдүй цогцолбор сургууль | | 1 416 212,2 | |
| 11 | Хүмүүнлэг сургууль | | 732 933,4 | |
| 12 | МГССургалттай сургууль | | 523 621,4 | |
| 13 | Мандал сургууль | | 953 267,0 | |
| 14 | Эрүүл мэндийн төв | | | 234 887,0 |
| НИЙТ ДҮН | | 2 480 222,1 | 5 216 136,5 | 234 887,0 |

5. Сумын 2019 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай:

1. Сумын татварын болон татварын бус орлого 562 266,5 мянган төгрөг;
2. Сумын төсөвт аймагийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1 614 842,7 мянган төгрөг;
3. Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжих 51 559,9
4. Сумын төсөвт аймгийн төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг 7 879 685,8 мянган төгрөг.